

**ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН
2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН
(2023.12.11-2024.12.02)**

2024 оны 11 дүгээр сарын 27

Улаанбаатар хот

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
Стратегийн зорилго 1. Гадаадын иргэн, харьяалалгүй хүний бүртгэл, мэдээлэл, хяналтын тогтолцоог сайжруулна. (Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого 2.7.3), (Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл 2.7.3), (Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр 4.3.9), (Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө 2.5.2, 2.7.5), (Гадаадын иргэн, харьяатын газрын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөний 3,4,5,6 дугаар зорилт)							
Зорилт 1. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт Технологийн дэвшилд тулгуурлан гадаадын иргэний бүртгэл, хяналтыг сайжруулна.							
1.	“Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” системд нэмэлт хөгжүүлэлт хийх	Урсгал зардал	Системийг бүрэн нэвтрүүлсэн эсэх	1	1	Уригч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, гадаадын иргэн танилт нэвтрэлтийн ДАН системээр дамжуулан “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” системд нэвтэрч визийн зөвшөөрөл, виз, оршин суух зөвшөөрлийн хүсэлт гаргах болон гадаадын иргэнийг бүртгэх үйлчилгээг 2023 оны 12 дугаар 11-ний өдрөөс бүрэн ажиллагаанд оруулсан. Мөн виз, оршин суух үнэмлэх хэвлэлтийг системээс хийх, оршин суух үнэмлэх хүргэлт, иргэн, аж ахуйн нэгж хүсэлтээ цахимаар цуцлах, олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрууд системд нэвтэрч хүсэлт илгээх болон хяналтын улсын байцаагчид системд нэвтэрч зөрчил шалган шийдвэрлэсэн дүгнэлтийг оруулах модулийг 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 03 дугаар сарын 28-ны өдрүүдэд тус тус шинээр хөгжүүлсэн. Уригчтай 54 ангиллын визийг цахимаар олгох хөгжүүлэлтийг 09 дүгээр сарын 10-ны өдөр, оршин	100

1	2	3	4	5	6	7	8
						<p>суух зөвшөөрлийн хугацаа сунгах болон хасалт үйлчилгээг 11 дүгээр сарын 04-ний өдрөөс системд хийж, тайлант хугацаанд нийт 619 удаагийн засвар шинэчлэлтийг хийж гүйцэтгэсэн. Түүнчлэн салбар, төлөөлөгчийн газар байгуулах, мэдээлэл шинэчлэх, зөвшөөрлийн хугацаа сунгах, хүчингүй болгох, зөрчил, саатуулалт, гарах сануулга, албан шаардлага, гарахыг түдгэлзүүлэх болон албадан гаргалтын бүртгэл, хяналт үйлчилгээний хөгжүүлэлтийг хийж, 10 дугаар сарын 31-ний өдрөөс тестийн системд шалгаж байна.</p> <p>Эдийн засаг хөгжлийн яам, Азийн хөгжлийн банктай хамтран хэрэгжүүлж буй "МОН3936: Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төсөл"-ийн бүрэлдэхүүн хэсэг ЗҮ-03: "Гадаадын иргэний мэдээллийн нэгдсэн систем хөгжүүлэлт"-ийн хүрээнд нэмэлт хөгжүүлэлтийг хийж, байгууллагаас үзүүлж буй бүх төрлийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэхээр ажиллаж байна. Төслийн хүрээнд хэрэглэгчийн шаардлага, эхлэлийн тайлан, нарийвчилсан дизайны тайлан, хөгжүүлэлтийн бета хувилбар, туршилтын хувилбарын тайланг хүлээн авч, саналыг төслийн нэгжид хүргүүлсэн. Гэрээний дагуу 12 дугаар сард багтаан бүх үйлчилгээг бүрэн цахимжуулж, үйл ажиллагаанд нэвтрүүлэхээр системийн хөгжүүлэлт хийгдэж байна.</p>	
2.	Монгол Улсаас хилийн чанадад суугаа дипломат төлөөлөгчийн газруудыг "Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан"-тай холбох	Урсгал зардал	Мэдээллийн нэгдсэн сантай холбосон эсэх	-	1	Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Бээжин, Эрээн, Шанхай, Хөх хотод суугаа дипломат төлөөлөгчийн газруудыг "Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан" системд 04 дүгээр сарын 12-ны өдөр холбож, байгууллагаас гадаадын иргэнд олгосон визийн зөвшөөрлийг системд хандан харах эрх нээж өгсөн. Түүнчлэн 11 дүгээр сарын 18-ны өдөр нэмэлтээр 32 элчин сайдын яам, 10 консулын газар, 4 төлөөлөгчийн газарт хандах эрх нээж өгснөөр нийт 50 ДТГ-ыг системд холбоод байна.	100

1	2	3	4	5	6	7	8
3.	Визийн зөвшөөрлийн загварыг шинэчилж, цахим хэлбэрт шилжүүлэх	Урсгал зардал	Загварыг цахим хэлбэрт шилжүүлсэн эсэх	-	1	Цаасан хэлбэрээр олгож байсан визийн зөвшөөрлийг QR код бүхий цахим хэлбэрт шилжүүлж, загварыг байгууллагын даргын 01 дүгээр сарын 17-ны өдрийн А/30 дугаар тушаалаар баталсан. Шинэчилсэн загварыг мөн өдрийн 01/152 дугаар албан бичгээр Гадаад харилцааны яаманд хүргүүлж, “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан”-д холбогдох хөгжүүлэлтийг хийн 01 дүгээр сарын 30-ны өдрөөс үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байна.	100
4.	Цахимаар олгох визийн ангиллыг нэмэгдүүлэх	Урсгал зардал	Цахимаар олгох визийн ангиллын тоо	4	64	Цахимаар 4 ангиллын виз олгож байгааг 64 буюу бүх ангилал болгож нэмэгдүүлэхээр Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 192 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын виз олгох журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд 2024 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 01/231 дүгээр албан бичгээр хүргүүлсэн. Тус тогтоолын хавсралтад Засгийн газрын 2024 оны 03 дугаар 13-ны өдрийн 107 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулж, “Монгол Улсын виз олгох журам”-ын 2.1.1-2.1.6-д заасан ангиллын визийг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, 2.1.7-2.1.8, 2.2-2.9-д заасан ангиллын визийг гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага цахимаар олгож болохоор зохицуулсан. Дээрх өөрчлөлтийн хүрээнд уригчтай 54 ангиллын визийг цахимаар олгох хөгжүүлэлтийг “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан (isf.mn)” системд хийж, байгууллагын даргын 2024 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн А/366 дугаар тушаалаар тус үйл ажиллагааг хэрэгжүүлж эхлэв. Уригчтай 54 ангиллын визийн хүсэлтийг 09 дүгээр сарын 10-ны өдрөөс хүлээн авч, 11 дүгээр сарын 19-ний өдрийн байдлаар 17 улсын 284 иргэнд цахим виз олгосон байна.	100
Хэсгийн дундаж үнэлгээ: 100 хувь							

1	2	3	4	5	6	7	8
Зорилт 2. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт Гадаадын иргэнд холбогдох асуудлаар зөвшөөрөл, бүртгэл, хяналтыг эрхлэн зохион байгуулна.							
5.	Гадаадын иргэнд олгох Монгол Улсын виз, зөвшөөрлийн үйлчилгээг зохион байгуулах	Урсгал зардал	Гадаадын иргэнд Монгол Улсын виз, зөвшөөрөл олгосон хувь	100	100	Тайлант хугацаанд түр ирэгч, албан болон хувийн хэргээр оршин суухаар ирэх хүсэлт гаргасан байгууллага, аж ахуйн нэгж, иргэний хүсэлтийг үндэслэн гадаадын 44064 иргэнд визийн зөвшөөрөл олгож, үүнээс 34768 иргэний визийн зөвшөөрлийг хилийн чанад дахь Дипломат төлөөлөгчийн газарт, хилийн боомтод виз олгох 9296 иргэний визийн зөвшөөрлийг боомт, орон нутаг дахь нэгжид илгээлээ. Хилийн боомтод 10907, төвд 694, нийт 11601 иргэнд зохих ангиллын Монгол Улсын виз олгосон. Цахим визийн evisa.mn системээр 77 улсын 86111 иргэнд цахим виз олгож, виз, визийн зөвшөөрөл олгохоос татгалзсан хугацаа дуусаагүй, бичиг баримтын бүрдэл дутуу шалтгаанаар 848 иргэнд виз олгохоос татгалзсан байна.	100
6.	Гадаадын иргэний бүртгэл, хяналтыг эрхлэх	Урсгал зардал	Гадаадын иргэний бүртгэл хийж, бүртгэлд хяналт тавьсан хувь	100	100	Гадаадын иргэнийг уригч 587 аж ахуйн нэгж, иргэний хүсэлтийн дагуу 1860 гадаадын иргэний виз, бүртгэлийн талаарх мэдээлэл бүхий тодорхойлолт олгож, Монгол Улсад түр ирэгчээр ирсэн 21685 гадаадын иргэний хаягийг бүртгэж, нутаг буцсан, статус өөрчлөгдсөн 13946 иргэний бүртгэлд хасалт хийсэн. Монгол Улсад 90 хүртэл хоногийн визтэй ирсэн болон визгүй зорчдог улсын түр ирэгч гадаадын иргэдээс тус улсад байх хугацааг сунгуулах хүсэлтийг хянан 3313 иргэний байх хугацааг 30 хүртэл хоногоор сунгасан. Монгол Улсад оршин суух 47571 үнэмлэхийг шинээр хэвлэн 33528 иргэний үнэмлэхийг олгосон байна. “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” (isf.mn) системээр 44064 иргэний визийн зөвшөөрөл, 24547 иргэний оршин суух зөвшөөрлийн олголт, 694 иргэний виз олголт, 48 цагийн бүртгэл хийлгэх 18372 иргэний хүсэлтийг хүлээн авч хянан шийдвэрлэв.	100

1	2	3	4	5	6	7	8
						Eimmigration.mn системээр 3313 иргэний байх хугацаа сунгалт, 7494 уригч иргэн, байгууллага, аж ахуйн нэгжийн 37426 иргэний оршин суух зөвшөөрлийн хугацаа сунгалт, 5731 уригч иргэн, байгууллага, аж ахуйн нэгжийн оршин суух зөвшөөрөлтэй 12815 иргэний бүртгэлд хасалт хийж, 362 уригч иргэн, байгууллага, аж ахуйн нэгжийн 592 иргэний паспортод өөрчлөлт, 59 уригч иргэн, байгууллага, аж ахуйн нэгжийн 172 иргэний хаягт өөрчлөлт, 70 уригч иргэн, байгууллага, аж ахуйн нэгжийн оршин суух үнэмлэх дахин авах 296 иргэн, цагаачийн гарах-орох мэдэгдэл хүссэн 1834 иргэний хүсэлтийг тус тус хүлээн авч хянан шийдвэрлэсэн.	
7.	Гадаадын иргэнд үзүүлэх үйлчилгээний чиглэлээр иргэдийг зөвлөгөө, мэдээллээр хангах	Урсгал зардал	Зөвлөгөө, мэдээллийн хэлбэр, иргэнд үйлчилгээ хүргэсэн тоо	3/28573	3/28000	Лавлах утасны 1800-1882 мэдээллийн төв болон боомт, орон нутаг дахь нэгжийн зөвлөгөө, мэдээлэл хариуцсан албан хаагчид гадаадын иргэний Монгол Улсад албан болон хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл, түүний сунгалт, түр ирэгчийн бүртгэл, хасалт, визийн хугацааны сунгалтын асуудлаар 76983 иргэнд утсаар, 4522 иргэнд биечлэн, 1139 иргэнд цахимаар, нийт 82644 иргэнд зөвлөгөө, мэдээлэл өгсөн.	100
8.	Монгол Улсын иргэний харьяаллын талаарх хүсэлтийг хүлээн авч, холбогдох ажиллагааг зохион байгуулах	Урсгал зардал	Зохион байгуулалтын ажлын хувь	100	100	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 3 удаагийн зарлигаар Бүгд Найрамдах Хятад Улсын 2, Оросын Холбооны Улсын 1, нийт 3 иргэн Монгол Улсын харьяат болсон. Харьяат болох хүсэлт гаргасан 13 иргэний хүсэлтийг хүлээн авч, 7 иргэний хүсэлтэд санал авахаар холбогдох байгууллагад хүргүүлсэн. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын 2, Оросын Холбооны Улсын 1, Япон Улсын 1, нийт 4 иргэнтэй ярилцлага хийж, 6 иргэний хүсэлт, холбогдох баримт бичгийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар (ЗГХЭГ)-т танилцуулан Ерөнхийлөгчийн Тамгын газар (ЕТГ)-т уламжилсан. Хуульд заасан шаардлага хангаагүй 5 иргэний хүсэлтийг түдгэлзүүлсэн байна. Ерөнхийлөгчийн 12 удаагийн зарлигаар Монгол Улсын харьяатаас гарсан 271 иргэний мэдээллийг холбогдох байгууллагуудад хүргүүлэн “Гадаадын иргэний бүртгэл мэдээллийн нэгдсэн сан”-д бүртгэж,	100

1	2	3	4	5	6	7	8
						<p>баяжилт хийлээ. Харьятаас гарах хүсэлт гаргасан 160 иргэний хүсэлтийг хүлээн авч, 142 иргэний хүсэлт, баримт бичигт холбогдох байгууллагуудаас санал аван 126 иргэний хүсэлтийг ЗГХЭГ-т хүргүүлж, 140 иргэний хүсэлтийг ЕТГ-т уламжилсан.</p> <p>Ерөнхийлөгчийн 2 удаагийн зарлигаар 2 иргэн Монгол Улсын иргэний харьяаллаа сэргээн тогтоолгосон байна. Иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох хүсэлт гаргасан 14 иргэний хүсэлтийг хүлээн авч, 13 иргэний хүсэлтэд холбогдох байгууллагаас санал аван 14 иргэний хүсэлтийг ЗГХЭГ-т, 16 иргэний хүсэлтийг ЕТГ-т уламжилж ажиллалаа.</p> <p>Зохион байгуулалтын ажлын гүйцэтгэл 100 хувь хангагдсан.</p>	
9.	Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэн авах тухай гадаадын иргэний хүсэлтийг шийдвэрлэх, үрчлэлтийн дараах хяналт тавих	Урсгал зардал	Зохион байгуулалтын ажлын хувь	100	100	<p>Тайлант хугацаанд Монгол Улсын харьяат хүүхдийг гадаадын иргэнд үрчлүүлээгүй ба 11 дүгээр сарын 19-ний өдрийн байдлаар Монгол Улсын харьяат 277 хүүхдийг 18 улсын иргэн, гэр бүлд үрчлүүлээд байна. Америкийн Нэгдсэн Улсын иргэн, гэр бүлд үрчлэгдсэн 9, Бүгд Найрамдах Итали Улсын иргэн, гэр бүлд үрчлэгдсэн 13, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын иргэн гэр бүлд үрчлэгдсэн 1, нийт 23 хүүхдийн өсөлт хөгжилтийн талаарх тайланг хүлээн авч, “Гадаад улсын иргэнд үрчлүүлсэн Монгол Улсын харьяат хүүхдийн мэдээллийн сан”-д бүртгэсэн.</p> <p>Байгууллагын даргын 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/491 дүгээр тушаалаар Захиргаа, удирдлагын газрын дарга, Иргэний харьяаллын газрын дарга, олон нийттэй харилцах ахлах мэргэжилтэн нар Америкийн Нэгдсэн Улсын гэр бүлд үрчлэгдсэн Монгол Улсын харьяат 7 хүүхдийн аж байдалтай танилцах, үрчлэлтийн дараах хяналт тавих зорилгоор тус улсад 12 хоногийн хугацаатай албан томилолтоор ажиллалаа.</p> <p>Зохион байгуулалтын ажлын гүйцэтгэл 100 хувь хангагдсан.</p>	100

1	2	3	4	5	6	7	8
10.	Олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын зөвшөөрлийг шийдвэрлэх, хяналт тавих	Урсгал зардал	Зөвшөөрөл олгосон, сунгасан, хүчингүй болгосон, хяналт тавьсан ажлын гүйцэтгэл	100	100	Байгууллагын даргын дэргэдэх “Мэргэжлийн зөвлөл”-ийн 3 удаагийн хурлаар олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 6 байгууллагад шинээр олгож, 14 байгууллагын зөвшөөрлийг сунган 3 байгууллагын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгосон. Нийт 86 байгууллагын үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хүлээн авч, хяналт тавьж ажиллалаа. Монгол Улсад 11 дүгээр сарын 19-ний өдрийн байдлаар 84 олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газар үйл ажиллагаа явуулж байна. Ажлын гүйцэтгэл 100 хувь хангагдсан.	100
11.	Иргэний харьяаллын зарим асуудлыг шийдвэрлэх олон улсын хууль тогтоомж, хэрэглээний талаар харьцуулсан судалгаа хийх	Урсгал зардал	Судалгаа, тайлангийн тоо	1	1	Улс орнуудын иргэний харьяаллын талаарх хууль тогтоомжийг Монгол Улсын хууль, эрх зүйн орчинтой харьцуулан судалж “Монгол Улсын иргэний харьяаллын асуудал ба эрх зүйн орчин” сэдэвт судалгааны ажил хийж гүйцэтгэлээ. Уг судалгааны ажлаараа Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын алба болон Стратеги судалгааны хүрээлэнгээс эрхлэн гаргадаг “Стратегийн судалгаа” сэтгүүлийн №93 дугаарт эрдэм шинжилгээний өгүүлэл бичин нийтлүүлсэн. Мөн ҮАБЗ-ийн Стратеги судалгааны хүрээлэн, Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний хүрээлэн хамтран зохион байгуулсан “Дотоод аюулгүй байдлын тулгамдсан асуудал, шийдэл” сэдэвт эрдэм шинжилгээний хуралд илтгэн тавин оролцсон болно.	100
12.	Монгол Улсын нутаг дэвсгэрт төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуулах	Урсгал зардал	Хяналт шалгалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100	100	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг зөрчихөөс урьдчилан сэргийлэх, хууль тогтоомж зөрчсөн үйлдлийг илрүүлэх, таслан зогсоох зорилгоор төлөвлөгөөт 37, төлөвлөгөөт бус 343, нийт 380 хяналт шалгалтыг зохион байгуулсан. Хяналт шалгалтаар 1183 аж ахуйн нэгж,	100

1	2	3	4	5	6	7	8
						байгууллагын 15567 гадаадын иргэний паспорт, түүнийг орлох баримт бичгийг шалгаж, 762 зөрчлийг илрүүлэн 407 зөрчилд торгох шийтгэл оногдуулж, 318 иргэнийг албадан гаргаж, 41 аж ахуйн нэгж, байгууллагад албан шаардлага өгсөн байна. Хяналт шалгалтын төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувь хангагдсан.	
13.	Гадаадын иргэний хяналтыг сайжруулж, хууль зөрчсөн иргэнд хориг арга хэмжээг авч хэрэгжүүлэх	Урсгал зардал	Хууль зөрчсөн иргэнд авсан хориг арга хэмжээний хувь	100	100	Хууль тогтоомж зөрчсөн гадаадын 31 улсын 795 иргэнийг байгууллагын даргын 241 удаагийн тушаалаар Монгол Улсаас албадан гаргаж, 12 улсын 47 иргэнийг 38 удаагийн тушаалаар Монгол Улсаас албадан гаргасан шийдвэрийг цуцалсан. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасан үндэслэлээр 7 улсын 57 иргэнийг 49 удаагийн тушаалаар Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлж, гарахыг түдгэлзүүлсэн 4 улсын 30 иргэний хилээр нэвтрэх эрхийг 28 удаагийн тушаалаар сэргээсэн байна. Хууль зөрчсөн иргэнд авсан хориг арга хэмжээний гүйцэтгэл 100 хувь.	100
Хэсгийн дундаж үнэлгээ: 100 хувь							
Зорилт 3. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт Олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, санхүүгийн чадавхыг бэхжүүлнэ.							
14.	Гадаад харилцааг өргөжүүлж, хамтын ажиллагааг бэхжүүлэх	Урсгал зардал	Байгуулсан санамж бичиг, гадаад улсад хийсэн албан айлчлал, дотоод уулзалт, хүлээн авалтын тоо	2/11/35	1/4/30	“Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гадаадын иргэн, харьяатын газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Үндэсний цагаачлалын удирдах газар хоорондын цагаачлалын салбарын хамтын ажиллагааг бэхжүүлэх тухай харилцан ойлголцлын санамж бичиг”-т 04 дүгээр сарын 08-ны өдөр Бээжин хотноо гарын үсэн зурж, санамж бичгийг байгуулав. Мөн Дорноговь аймаг дахь газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Эрээн хотын Дотоодыг хамгаалах товчоо хоорондын уулзалтын протоколыг 07 дугаар сарын 07-ны өдөр байгууллаа.	100

1	2	3	4	5	6	7	8
						<p>Тайлант хугацаанд Бүгд Найрамдах Солонгос Улсын Шилжилт хөдөлгөөний судалгаа, сургалтын төвд ажлын айлчлал хийх, иргэдийн зорчих нөхцөлийг хөнгөвчлөх чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээг эрчимжүүлэх, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Үндэсний цагаачлалын удирдах газартай санамж бичиг байгуулах, Өмнөд бүс дэх газрын барилгын ажлын явцын талаар хэлэлцэх, “Монгол, Хятадын Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах тухай” хэлэлцээрийн хүрээнд холбогдох уулзалтууд болон “Бүх нийтийн нийгмийн аюулгүй байдлын форум”-д оролцох, Америкийн Нэгдсэн Улсын иргэн, гэр бүлд үрчлэгдсэн Монгол хүүхдүүдийн аж байдалтай танилцах, хиймэл оюун ухаанд суурилсан технологийн чиглэлээр зохион байгуулсан чуулга уулзалтад тус тус оролцох зорилгоор байгууллагын дарга, Захиргаа, удирдлагын газрын дарга тэргүүтэй 19 төлөөлөгч нийт 7 удаа дээрх улсуудад ажлын айлчлал хийсэн.</p> <p>Мөн байгууллагын дарга гадаад улсаас Монгол Улсад суугаа элчин сайд, консул, олон улсын байгууллагын төлөөлөгчтэй нийт 34 удаагийн албан уулзалт хийж, холбогдох арга хэмжээнд оролцсон байна.</p>	
15.	Гадаад хамтын ажиллагааны хүрээнд хөтөлбөр хэрэгжүүлэх төсөл,	Буцалтгүй тусламж	Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн тоо	1	1	<p>Эдийн засаг хөгжлийн яам, Азийн хөгжлийн банктэй хамтран хэрэгжүүлж буй "МОН3936: Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төсөл"-ийн бүрэлдэхүүн хэсэг ЗҮ-03: “Гадаадын иргэний мэдээллийн нэгдсэн систем хөгжүүлэлт”-ийн хүрээнд байгууллагаас үзүүлж буй бүх төрлийн үйлчилгээг 12 дугаар сард багтаан цахим хэлбэрт шилжүүлж, үйл ажиллагаанд нэвтрүүлэхээр төлөвлөж байна.</p> <p>Мөн “Гадаадын иргэн, харьяатын газрын иргэдэд үйлчлэх танхимыг иж бүрэн сэргээн засварлах төсөл”-ийн саналыг Туркийн хамтын ажиллагаа зохицуулах агентлаг (ТИКА)-т 02 дугаар сарын 23-ны өдөр, баримт бичгийн хуурмаглалыг таних тоног</p>	90

1	2	3	4	5	6	7	8
						төхөөрөмж нийлүүлэх, сургалт зохион байгуулах чиглэлээр хамтарсан төсөл хэрэгжүүлэх хүсэлтийг төслийн саналын хамт Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагад 05 дугаар сарын 09-ний өдөр, Америкийн Нэгдсэн Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яаманд 05 дугаар сарын 14-ний өдөр, Бүгд Найрамдах Солонгос Улсын Санхүү, эдийн засгийн яамны "Мэдлэг хуваалцах хөтөлбөр" (KSP)-ийн 2025-2026 онд хэрэгжүүлэх төсөлд хамрагдах хүсэлтийг 11 дүгээр сарын 15-ны өдөр тус тус хүргүүлээд байна.	
16.	Гадаад сургалт, олон улсын хурал болон туршлага солилцох уулзалтад албан хаагчдыг оролцуулах	Буцалтгүй тусламж	Гадаад сургалт, олон улсын хурал, уулзалт, хамрагдсан албан хаагчийн тоо	7/6/6/88	4/2/1/35	Тайлант хугацаанд гадаад улсад зохион байгуулагдсан 12 удаагийн сургалтад 42 албан хаагч, 3 удаагийн олон улсын хурал, зөвлөгөөнд 4 албан хаагч, 6 удаагийн туршлага солилцох уулзалтад 21 албан хаагч, нийт 67 албан хаагчийг хамруулж, мэдлэг, чадавхыг дээшлүүлэн олон улсын туршлагаас суралцах боломж, нөхцөлөөр хангалаа.	100
17.	Монгол Улсын хууль тогтоомжид санал хүргүүлэх, байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагаанд хамаарах эрх зүйн баримт бичгийг боловсронгуй болгох	Урсгал зардал	Санал хүргүүлсэн хууль тогтоомж, боловсруулж баталсан эрх зүйн баримт бичгийн тоо	11/6	5/5	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Харьяатын тухай хууль, Гэр бүлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдэд санал боловсруулж, 02 дугаар сарын 14-ний өдрийн 01/339, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгах саналыг 05 дугаар сарын 21-ний өдрийн 01/1067, Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуулийн зохицуулалтад өөрчлөлт оруулах тухай саналыг 11 дүгээр сарын 02-ны өдрийн 01/2302 дугаар албан бичгээр тус тус Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн. "Монгол Улсын виз олгох журам"-ын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Засгийн газрын 2024 оны 03 дугаар 13-ны өдрийн 107 дугаар тогтоол, Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн "Журам батлах тухай" 160 дугаар тогтоолоор байгууллагын албан хаагчдын албан тушаалын	100

1	2	3	4	5	6	7	8
						<p>ангилал, зэрэглэл, зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журмыг тус тус батлууллаа.</p> <p>Байгууллагын даргын энэ оны А/159 дүгээр тушаалаар “Гадаадын иргэн, харьяатын газрын албан хаагчид албан тушаалын цол олгох, хэрэглэх, хураах журам”, А/241 дүгээр тушаалаар “Гадаадын иргэн, харьяатын газрын төрийн тусгай албан хаагчид мэргэшлийн зэрэг тогтоох шалгуур үзүүлэлт, түүнийг олгох журам”, А/243 дугаар тушаалаар “Гадаадын иргэнийг Монгол улсаас албадан гаргах шийдвэрийг хэрэгжүүлэх журам”; А/406 дугаар тушаалаар “Гадаадын иргэн, харьяатын газрын төрийн тусгай албан хаагчид хилийн боомт, орон нутагт ажилласан хугацааны мөнгөн урамшуулал олгох журам”, А/407 дугаар тушаалаар “Гадаадын иргэн, харьяатын газрын албан хаагчийг зайнаас ажиллуулах журам”, А/454 дүгээр тушаалаар “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг тус тус шинээр болон шинэчлэн баталж, үйл ажиллагаандаа мөрдөж байна.</p>	
18.	<p>Байгууллагын зохион байгуулалтын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай төсөл боловсруулан эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэх</p>	Урсгал зардал	Төсөл боловсруулан хүргүүлсэн эсэх	-	1	<p>2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар албан хаагчид нь төрийн тусгай албан хаагчийн ангилалд багтсан. Хуулийн 41.14, 41.18-д “Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан тушаалын ангилал, зэрэглэл, албан хаагчийн албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн алба хаасан хугацааны, цолны, мэргэшлийн, эрдмийн зэргийн нэмэгдэл олгох журам, нэмэгдлийн хэмжээг Засгийн газраас тогтооно” гэж заасны дагуу Төрийн албаны хууль тогтоомжид нийцүүлэн Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн “Журам батлах тухай” 160 дугаар тогтоолоор байгууллагын албан хаагчдын албан тушаалын ангилал, зэрэглэл, зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журмыг шинээр баталсан.</p> <p>Гадаадын иргэн, харьяатын газрын орон тоонд өөрчлөлт оруулах саналыг боловсруулан Хууль зүй,</p>	100

1	2	3	4	5	6	7	8
						<p>дотоод хэргийн яаманд хүргүүлснээр Гадаадын иргэн, харьяатын газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн батлах тухай Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн А/129 дүгээр тушаал батлагдсан. Мөн байгууллагын даргын Гадаадын иргэн, харьяатын газрын төвийн зохион байгуулалтын нэгжүүдийн ажил, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай А/157, Гадаадын иргэн, харьяатын газрын хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн орон тоо, албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн батлах тухай А/158 дугаар тушаалыг тус тус баталлаа.</p>	
19.	<p>Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2024 оны төлөвлөгөө батлан хэрэгжилтийг хангах</p>	Урсгал зардал	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	97.1	100	<p>Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр (2023-2030)-ийг хэрэгжүүлэх 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, Гадаадын иргэн, харьяатын газраас авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг тус тус баталж, www.immigration.gov.mn цахим хуудсанд нээлттэй байршуулав.</p> <p>Тайлант хугацаанд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлыг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулахаар нийт 74 албан хаагч, иргэний баримт бичгийг Авлигатай тэмцэх газарт хүргүүлж, дүгнэлтийг үндэслэн тухайн албан тушаалд томилох шийдвэрийг гаргасан.</p> <p>“Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн систем”-д үүсгэсэн мэдүүлэг гаргагч нийт албан тушаалтнуудын 2023 оны мэдүүлгийг хуулийн хугацаанд шинэчлэн гаргуулж, ХАСХОМ-ийн 2023 оны тайлан, ХАС-ын хураангуй, ХОМ-ын хураангуй</p>	90

1	2	3	4	5	6	7	8
						<p>тайланг цахимаар Авлигатай тэмцэх газарт хүргүүлэв.</p> <p>Авлигатай тэмцэх газраас авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэрэгтэй тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх, иргэд, олон нийтийн авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх зорилгоор эрхлэн гаргадаг “Шударга ёс” сэтгүүлийн 2024/01/27 Дорноговь аймаг дахь газрын ахлах мэргэжилтэн П.Гантулгын "Авлигын мөн чанар, хор уршиг, Монголчуудын авлигатай тэмцсэн түүхэн уламжлал" сэдэвт илтгэл нийтлэгдсэн.</p> <p>Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдлын 2023 оны тайланг төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем (ERP)-д нээлттэй байршуулж, албан хаагчдад танилцууллаа.</p> <p>Төлөвлөгөөний биелэлт 91.4 хувийн гүйцэтгэлтэй.</p>	
20.	Албан хаагчийн нийгмийн баталгааг хангах үйл ажиллагааны 2024 оны төлөвлөгөө батлан хэрэгжилтийг хангах	Урсгал зардал	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	91.8	100	<p>“Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх Гадаадын иргэн, харьяатын газрын төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах 2024 оны төлөвлөгөөг салбар зөвлөлийн 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01 дүгээр хурлаар батлуулсан.</p> <p>Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн, хуулийн 41.20-д “Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагчийн ажилласан нэг жилийг нэг жил гурван сар ажилласанд тооцох ...” гэж заасны дагуу байгууллагын албан хаагчдын төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг Хүний нөөцийн удирдлага, мэдээллийн тогтолцоо (ХНУМТ) цахим системд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс нэг жилийг нэг жил гурван сараар тооцогдохоор нэмэлт хөгжүүлэлт хийлгэх хүсэлтийг 02 дугаар сарын 16-ны өдрийн 01/357 албан бичгээр Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн.</p>	90

1	2	3	4	5	6	7	8
						<p>Төрийн албаны хуулийн 57.2.3, Засгийн газрын “Журам батлах тухай” 160 дугаар тогтоолд заасны дагуу албан хаагчид цол олгох, хураах, хэрэглэх, мэргэшлийн зэрэг, түүний нэмэгдэл олгох журмыг шинээр боловсруулж, байгууллагын даргын А/159, А/241 дүгээр тушаалаар тус тус баталж, 201 албан хаагчийн албан тушаалын үндсэн цалин, 42 албан хаагчийн зэрэг дэв, 198 албан хаагчийн цол, 178 албан хаагчийн мэргэшлийн зэргийн нэмэгдэл хөлсийг шинээр болон шинэчлэн тогтоосон.</p> <p>Хууль тогтоомж, санхүүгийн эх үүсвэрт нийцүүлэн байгууллагын даргын 04 дүгээр сарын 26-ны өдрийн А/154 дүгээр тушаалаар хоолны нөхөх төлбөрийг 34,000, унааны нөхөх төлбөрийг 1,000 төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоож, 04 дүгээр сарын 01-ний өдрөөс олгож эхэлснээр цалин, хөлсний орлого дунджаар 400,000 төгрөгөөр нэмэгдлээ.</p> <p>Төлөвлөгөөний хүрээнд Төрийн тусгай албан хаагчийн нэгдсэн эмнэлгийн 11 төрлийн эрүүл мэндийн шинжилгээ, эмчийн үзлэгт төв байгууллагын 21 албан хаагчийг хамруулав.</p> <p>"Хөдөлмөрийн дотоод журам"-ын дагуу гэр бүлийн гишүүн нь нас барсан 2 албан хаагчид 1,320,000, өвчний улмаас нас барсан 1 албан хаагчийн гэр бүлд 3,000,000, ахмад настны тэтгэвэрт гарсан 1 албан хаагчид 3,000,000 төгрөгийн буцалтгүй тусламжийг байгууллагын даргын 02 дугаар сарын 20-ны өдрийн Б/57, 05 дугаар сарын 28-ны өдрийн Б/134, 08 дугаар сарын 27-ны өдрийн Б/204, 09 дүгээр сарын 20-ны өдрийн Б/252 дугаар тушаалаар тус тус олгосон.</p> <p>Төлөвлөгөөний биелэлт 90 хувийн гүйцэтгэлтэй.</p>	
21.	Байгууллагын 2024 оны сургалтын төлөвлөгөө батлан хэрэгжилтийг хангах	Урсгал зардал	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	99.3	100	<p>“Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх Гадаадын иргэн, харьяатын газрын 2024 оны сургалтын төлөвлөгөөг 01 дүгээр сарын 23-ны өдөр баталсан. Төлөвлөгөөний дагуу Удирдлагын академийн төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчийг чиглүүлэх сургалтад 5,</p>	90

1	2	3	4	5	6	7	8
						<p>мэргэшүүлэх сургалтад 5, дунд хугацааны давтан сургалтад 9, ахлах түшмэлийн багц сургалтад 3, эрхэлсэн түшмэлийн багц сургалтад 2, нийт 24 албан хаагчийг суралцуулсан.</p> <p>Байгууллагаас эрх зүйн шинэтгэлийг таниулан хувь хүний хөгжлийг дэмжих, албан хаагчийн чадавхыг дээшлүүлж, эерэг хандлагыг нэмэгдүүлэх, байгууллагын соёлыг дээшлүүлэх, ёс зүйг сайжруулах зорилгоор зохион байгуулсан 36 удаагийн сургалт, мэдээллийн арга хэмжээ, 2 удаагийн нэгдсэн сургалт, зөвлөгөөнд давхардсан тоогоор 2100 албан хаагч, бусад байгууллагаас зохион байгуулсан 10 удаагийн сургалтад 42 албан хаагчийг тус тус хамруулжээ. Түүнчлэн албан хаагчдыг ажлын байранд сургах, чадавхжуулах зорилгоор хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн 23 албан хаагчийг Виз, зөвшөөрлийн газар, Зөрчил шалган шийдвэрлэх газар, Мэдээллийн технологийн хэлтэс, Зөвлөгөө мэдээллийн хэлтэст дадлагажуулсан бол төвийн нэгжээс 2 албан хаагчийг Өмнөд бүс дэх газар, Баян-Өлгий аймаг дахь хэлтэст тус тус сэлгэн ажиллуулсан.</p> <p>Бүгд Найрамдах Энэтхэг улсад “Цахимжилт ба хүний нөөцийн менежментийн олон улсын сургалт”-д 1, “Англи хэлний мэдлэг дээшлүүлэх сургалт”-д 1, Унгар Улсын цагаачлалын байгууллагын үйл ажиллагаатай танилцах, туршлага судлах сургалтад 3, Америкийн Нэгдсэн Улсад зохион байгуулагдсан “Монгол Улсын хууль сахиулах байгууллагуудын албан хаагчдад зориулсан хилийн аюулгүй байдал, төмөр замын зорчигч, ачаа тээврийг шалгах нь” сэдэвт сургалтад 2, “Чикагогийн хууль сахиулах эмэгтэй алба хаагчдын холбоо”-оос зохион байгуулсан “Цагдаагийн эмэгтэй алба хаагчдын олон улсын холбооны 61 дэх удаагийн сургалт, хурал”-д 1, Бүгд Найрамдах Солонгос Улсын Олон улсын хамтын ажиллагааны агентлаг (КОЙКА)-тай хамтран хэрэгжүүлж буй төслийн хүрээнд “Монгол Улсын Гадаадын иргэн, харьяатын газрын</p>	

1	2	3	4	5	6	7	8
						<p>хүртээмжтэй үйлчилгээ, менежментийн чадавхыг бэхжүүлэх (2023-2025)” сэдэвт сургалтад 17, Бүгд Найрамдах Хятад Ард Улсад “Бүс ба зам санаачилгын түнш орнуудын угсаатны бодлого ба практикийн семинар”-т 5, “Боомт, орон нутгийн үйл ажиллагаатай танилцах, туршлага судлах” сургалтад 5, Шанхайн бизнесийн их сургуулиас зохион байгуулсан сургалтад 2, Швейцарын Холбооны Улсад “Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны 81 дүгээр чуулган”-д 1, Тайванийн Мин Чуан их сургуульд хятад хэлний мэдлэг дээшлүүлэх сургалтад 2, “Гадаад улс орнуудын цагаачлалын албаны ажилтнуудад зориулсан 2024 оны жишиг сургалт”-д 2, нийт 12 удаагийн сургалтад 42 албан хаагч хамрагдсан байна. Сургалтын төлөвлөгөөний хэрэгжилт 93.3 хувийн гүйцэтгэлтэй.</p>	
22.	<p>Жендерийн эрхийг хангах орон тооны бус зөвлөлийн үйл ажиллагааны 2024 оны төлөвлөгөө батлан хэрэгжилтийг хангах</p>	Урсгал зардал	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100	100	<p>Жендерийн эрхийг хангах орон тооны бус зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 03 дугаар сарын 29-ний өдөр баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> -Жендерийн үндэсний хорооноос зохион байгуулсан тэгш оролцоог хангах уриатай “Харилцан хүндэтгэе” аянд нэгдэж, аяны хүрээнд мэдээлэл, постер бэлтгэн 03 дугаар сарын 20-ны өдөр байгууллагын цахим хуудсаар нийт албан хаагчдад хүргэсэн. -“Шинэ үеийн манлайлал” сэдэвт сургалтыг 05 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулж, 112 албан хаагчийг цахим болон танхимаар хамрууллаа. -Боомт, орон нутаг дахь нэгжүүд “Ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх нь”, “Жендерийн эрх тэгш байдал, ажлын байрны бэлгийн дарамт”, “Жендерийн тухай ойлголт, Монгол улс дахь Жендерийн эрх тэгш байдал”, “Жендэр-эрэгтэйчүүдийн эрүүл мэнд” сэдэвт сургалтад 46 албан хаагчийг тус тус хамруулсан байна. -Төрийн тусгай албан хаагчийн Нэгдсэн эмнэлэг болон орон нутаг дахь нэгдсэн эмнэлэг, эрүүл 	100

1	2	3	4	5	6	7	8
						<p>мэндийн төвд 56 албан хаагчийг урьдчилан сэргийлэх үзлэг, эрүүл мэндийн шинжилгээнд хамрууллаа.</p> <p>-Виз, зөвшөөрлийн газрын албан хаагчдын хувцас солих өрөөг хүйсийн байдал, онцлог хэрэгцээнд нийцүүлэн засварлаж, 05 дугаар сарын 14-ний өдөр ашиглалтад оруулсан.</p> <p>-Төв байгууллага болон Баруун бүс дэх газрын албан хаагчдын цайны цагаар амрах, хооллох өрөөг стандартын дагуу иж бүрэн тохижуулсан.</p> <p>-Бага насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй 1 албан хаагчийг хүүхдээ “Эх нялхас, эрүүл мэндийн үндэсний төв”-д эмчлүүлж, сувилуулах нөхцөл боломжоор хангалаа.</p> <p>-Байгууллагын даргын 11 дүгээр сарын 13-ны өдрийн 01-02/60 дугаар удирдамжаар “Жендэрийн тэгш байдал ба хүний эрх” сэдэвт сургалтыг зохион байгуулж, 123 албан хаагч хамрагдлаа. Төлөвлөгөөний биелэлт 100 хувийн гүйцэтгэлтэй.</p>	
23.	Хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр “Эцэг, эхийн зөвлөл”-ийн үйл ажиллагааны 2024 оны төлөвлөгөө батлан хэрэгжилтийн хангах	Урсгал зардал	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100	100	<p>Эцэг, эхийн зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 01 дүгээр сарын 12-ны өдөр зөвлөлийн даргаар батлуулсан.</p> <p>-Байгууллагаас 6 албан хаагчийн сургуулийн насны 6 хүүхдийг спорт дугуйланд 7 хоногт 3 удаа хамруулсан бөгөөд нэмэлтээр 3 албан хаагчийн 5 хүүхэд хамрагдах хүсэлт ирүүлсэн.</p> <p>-Хан-Уул дүүргийн Спортын хорооноос бага насны хүүхдүүдийн дунд “Уран хөдөлгөөнт гимнастик”-ийн тэмцээн зохион байгуулахтай холбогдуулан байгууллагын дэргэдэх 223 дугаар цэцэрлэгийн хүүхдүүдийг 02 дугаар сарын 28-ны өдрөөс 04 дүгээр сарын 18-ны өдрийг хүртэлх хугацаанд спорт зааланд бэлтгэл хийх нөхцөл боломжоор хангалаа.</p> <p>-“Хүүхэд хүмүүжлийн эерэг арга” сэдэвт сургалтыг 05 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулж, 79 албан хаагчийг цахимаар болон танхимаар хамруулав.</p> <p>-Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд хүүхдэд шаардлагатай ур чадвар, хүүхдийг өсгөж</p>	100

1	2	3	4	5	6	7	8
						<p>хүмүүжүүлэхэд анхаарах зүйлс, эцэг, эхчүүдийн нийтлэг гаргадаг алдааны талаарх мэдээлэл агуулсан 2 удаагийн зөвлөмжийг 04 дүгээр сарын 12, 25-ны өдрүүдэд Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем (ERP)-д байршуулж, албан хаагчдад хүргэлээ.</p> <p>-Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн тохиолдуулан албан хаагчдын 23 хүүхдийг өдөр төв байгууллагын ажлын байр болон Чингис хаан олон улсын нисэх буудлын ирэгч, явагчийн танхим, агаарын зорчигч тээвэр, Гаалийн ерөнхий газрын дэргэдэх Эрэлч нохойн сургалтын төвтэй танилцуулах арга хэмжээг зохион байгуулсан.</p> <p>-Нийслэлийн хүүхэд, гэр бүл, хөгжийн хэлтсийн дарга Х.Оюунтуяатай хамтран “Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга” сэдэвт сургалтыг 09 дүгээр сарын 24-ний өдөр зохион байгуулж, 104 албан хаагчийг хамрууллаа.</p> <p>-Хууль зүй, дотоод хэргийн яамны дэргэдэх Хүүхдийн төлөө дэд зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайланг 11 дүгээр сарын 15-ны өдрийн 02/2263 дугаар албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>Төлөвлөгөөний биелэлт 100 хувийн гүйцэтгэлтэй.</p>	
24.	Байгууллагын үйл ажиллагаа, эрхлэх чиг үүрэгтэй холбоотой мэдээ, мэдээллийг олон нийтэд ил тод мэдээлэх	Урсгал зардал	Байгууллагын цахим хуудас, олон нийтийн цахим сүлжээнд байршуулсан мэдээлэл, сурталчилсан тоо	228/176 /489	150/120/3 00	<p>Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 72 мэдээ бэлтгэн цахим хуудаст 155 мэдээ, ярилцлага, видео, нээлттэй мэдээллийг нийтэлж, нийгмийн сүлжээн дэх байгууллагын цахим хуудас (facebook)-т 175 мэдээллийг байршууллаа.</p> <p>Бэлтгэсэн мэдээллийг давхардсан тоогоор 467 хэвлэл, мэдээллийн хэрэгсэл (380 сайт, 36 сонин, 51 телевиз)-ээр сурталчилсан.</p> <p>Тухайлбал “Гадаадын иргэний оршин суух үнэмлэхийг зөвхөн Чингэлтэй дүүргийн нэг цэгийн үйлчилгээний төвд олгоно” гарчигтай мэдээг 31 сайт, 5 телевиз, 3 сонинд, “Хууль бусаар орогнон, эрэн сурвалжлагдаж байсан гадаадын иргэнийг илрүүлэн албадан гаргалаа” мэдээг 19 сайт, 3 телевиз, 5 сонинд, “Өнгөрөгч онд 519 хяналт шалгалтыг зохион байгууллаа” мэдээг 12 сайт, 2 телевизээр, “2023 онд</p>	100

1	2	3	4	5	6	7	8
						цахим виз олголт 4 дахин өсжээ” мэдээг 18 сайтад тус тус нийтлүүлсэн байна. Мөн Хууль зүй, дотоод хэргийн сайд 03 дугаар сарын 11-ний өдөр байгууллагын үйл ажиллагаатай танилцах арга хэмжээнд Eagle, UBS телевиз, Zuv.mn сайтуудыг оролцуулж, мэдээ бэлтгүүлсэн ба тус арга хэмжээний мэдээллийг 25 сайт, Хууль зүй, дотоод хэргийн сайд болон байгууллагын даргын видео яриаг 6 сайт нийтэллээ. Түүнчлэн жуулчлах зорилгоор зорчиж буй гадаадын иргэдэд зориулсан санамж мэдээлэл 19 сайт, 2 телевизэд, 2024 оны үйл ажиллагааны эхний 4 сарын тоон мэдээлэл 14 сайт, 3 сонинд, гадаадын иргэнийг уригч иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад зориулсан зөвлөмж 22 сайт, 6 телевиз, 2 сонинд тус тус нийтлэгдсэн байна. Байгууллагын нийгмийн сүлжээн дэх цахим хуудаст тогтмол мэдээлэл байршуулснаар 23262 дагагчтай болж, сарын дундаж хандалт 28101 хүрсэн байна	
25.	Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шуурхай шийдвэрлэх	Урсгал зардал	Шийдвэрлэлтийн хувь	96.7	100	Тайлант хугацаанд байгууллагын төвд 782 (иргэнээс 3 талархал, 601 өргөдөл, 51 гомдол, албан хаагчдаас 127 өргөдөл), хилийн боомт, орон нутаг дахь нэгжүүдэд 148 (иргэнээс 85 өргөдөл, 6 гомдол, албан хаагчдаас 57 өргөдөл), нийт 930 өргөдлийг хүлээн авснаас 897 өргөдлийг шийдвэрлэсэн. Үүнээс 18 өргөдөл хугацаа хэтэрч шийдвэрлэгдсэн байна. Нийт өргөдөл, гомдлын шийдвэрлэлт 96.5 хувьтай, хуулийн хугацаанд буюу шийдвэрлэх шатанд 33 өргөдөл хянагдаж байна. Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах 11-11 төвөөс манай байгууллагад 55 өргөдөл (3 талархал, 14 өргөдөл, 38 гомдол) шилжүүлснийг хүлээн авч, шийдвэрлэсэн. Өргөдөл, гомдлын хагас жилийн тайланг 06 дугаар сарын 27-ны өдрийн 02/1323, гуравдугаар улирлын тайланг 10 дугаар сарын 01-ний өдрийн 02/1940 дугаар албан бичгээр тус тус Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.	90

1	2	3	4	5	6	7	8
26.	Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	Урсгал зардал	Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тоо	46	23	Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд 22 удаа хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн тайланг тухай бүр холбогдох байгууллагад хүргүүлэв. Үүнд: -Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2023 оны хэрэгжилтэд тус тус хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн Даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлснээр тайланг 2023 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 01/2163 дугаар албан бичгээр, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2024 оны хагас жилийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг 06 дугаар сарын 07-ны өдрийн 01/1190 дүгээр албан бичгээр тус тус Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн. -Хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн байгууллагад холбогдох арга хэмжээний 01-05, 07, 08 дугаар сарын хэрэгжилт, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2024 оны хагас жилийн хэрэгжилтэд нэмэлтээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн тайланг 03 дугаар сарын 04, 04 дүгээр сарын 05, 05 дугаар сарын 06, 06 дугаар сарын 10, 09 дүгээр сарын 05, 10 дугаар сарын 07, 08 дугаар сарын 26-ны өдрүүдэд байгууллагын даргад танилцуулан Хууль зүй, дотоод хэргийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт цахимаар илгээсэн.	90
27.	Байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	Урсгал зардал	Хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн тоо	1	18	Иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор байгууллагын үйл ажиллагаанд 20 удаа хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайлан боловсрууллаа. Үүнд:	100

1	2	3	4	5	6	7	8
						<p>-Гадаадын иргэн, харьяатын газрын 2023 оны жилийн эцсийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн нэгдсэн тайлан; -2023 оны 12 дугаар сар, 2024 оны 01-04 дүгээр сарын үйл ажиллагааны тайлан; -Байгууллагын даргын 2023 онд батлан гаргасан 510, 2024 оны 259 тушаал, шийдвэрийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлан; -Гадаадын иргэн, харьяатын газарт 2023 он, 2024 оны нэг болон гуравдугаар улиралд иргэн, албан хаагчаас ирүүлсэн өргөдөл, гомдлын агуулга болон шийдвэрлэлтэд хийсэн тайлан; -Байгууллагаас иргэдэд үзүүлж буй үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах чиглэлээр 8 зорилтын хүрээнд хийсэн судалгаа шинжилгээний тайлан; -Байгууллагаас хэрэгжүүлж буй хүний нөөцийг чадавхжуулах бодлого, төлөвлөлт, дотоодод чиглэсэн арга хэмжээний хэрэгжилтэд дүн шинжилгээ хийсэн судалгааны нэгдсэн тайлан; -Байгууллагын чиг үүргийн хүрээнд 2023 онд торгох шийтгэлээр шийтгүүлсэн гадаадын иргэн, харьяалалгүй хүний тоо өмнөх онуудаас эрс нэмэгдсэн үзүүлэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлан.</p>	
28.	Байгууллагын үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээ хийх	Урсгал зардал	Системд тайлагнасан тоо	2	2	Байгууллагын 2024 оны эрсдэлийг сааруулах үйл ажиллагаа буюу хариу арга хэмжээний төлөвлөгөөг 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдөр баталж, 12 дугаар сарын 25-ны өдрийн 09/2274 дүгээр албан бичгээр, эрсдэлийг сааруулах төлөвлөгөөний хагас жилийн хэрэгжилтийг 07 дугаар сарын 04-ний өдрийн 01/1365 дугаар, жилийн эцсийн хэрэгжилтийг 11 дүгээр сарын 27-ны өдрийн 08/2342 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд тус тус хүргүүлсэн.	100
29.	Нийцлийн болон санхүүгийн аудитын хяналт шалгалтыг зохион байгуулах	Урсгал зардал	Хяналт шалгалтын тоо	9	9	Байгууллагын 2024 оны дотоод аудитын үйл ажиллагааны болон дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу төсөв, санхүүгийн 8 болон нийцлийн чиглэлээр 4, нийт 12 удаагийн	100

1	2	3	4	5	6	7	8
						<p>төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ. Үүнд: Байгууллагын даргын 2024 оны 01-02/21, 01-02/27, 02/35, 01-02/48, 01-02/51, 01-02/58 дугаар удирдамжаар Зүүн бүс дэх газрын захиргаа, санхүүгийн үйл ажиллагаанд 05 дугаар сарын 06-ны өдрөөс 10-ны өдрүүдэд гүйцэтгэлийн хяналт шалгалт, Агаарын замын боомт хариуцсан газрын зөрчил шалган шийдвэрлэлт, захиргаа, санхүүгийн 2023 он, 2024 оны нэгдүгээр улирлын үйл ажиллагаанд 05 дугаар сарын 20-ны өдрөөс 24-ний өдрүүдэд, Санхүү, хангалт, үйлчилгээний газрын 2024 оны хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаанд 06 дугаар сарын 24-ний өдрөөс 07 дугаар сарын 01-ний өдрүүдэд, Баруун бүс дэх газрын 2024 оны хагас жилийн захиргаа, санхүүгийн үйл ажиллагаа, Баян-Өлгий аймаг дахь хэлтсийн 2023 он, 2024 оны хагас жилийн захиргаа, санхүүгийн үйл ажиллагаанд 09 дүгээр сарын 15-ны өдрөөс 21-ний өдрүүдэд, Агаарын замын боомт хариуцсан газрын захиргаа, санхүүгийн үйл ажиллагаанд 10 дугаар сарын 08-ны өдөр гүйцэтгэлийн хяналт шалгалт, Хойд бүс дэх газрын 2024 оны эхний гуравдугаар улирлын захиргаа, санхүүгийн үйл ажиллагаанд 11 дүгээр сарын 06-ны өдрөөс 09-ний өдрүүдэд тус тус хяналт шалгалт хийн мэргэжил, арга зүйгээр хангаж, үр дүнг удирдлагад танилцууллаа.</p> <p>Мөн байгууллагын даргын баталсан хүчин төгөлдөр үйлчилж буй захиргааны хэм хэмжээний актад Захиргааны ерөнхий хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэгт заасны дагуу хяналт-шинжилгээ, нийцлийн аудит хийж, үр дүнгийн тайланг 04 дүгээр сарын 18-ны өдрийн 01/795 дугаар, дотоод аудитын 2024 оны хагас жилийн төлөвлөгөөний биелэлт болон Үндэсний аудитын газрын 2023 оны санхүүгийн аудитаар илэрсэн байгууллагад холбогдох зөрчлийг арилгах зөвлөмжийн хэрэгжилтийг 07 дугаар сарын 04-ний өдрийн 01/1367 дугаар, 01/1376 дугаар албан бичгээр тус тус Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.</p>	

1	2	3	4	5	6	7	8
30.	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн урсгал болон хөрөнгө оруулалтын төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах	Урсгал зардал	Батлагдсан төсвийн дүн	17.5 тэрбум	17 тэрбум	Энэ онд 17,092.3 сая төгрөгийн санхүүжилт авч, 11 дүгээр сарын 19-ний өдрийн байдлаар 14,810.3 сая төгрөгийн төсвийг зориулалтын дагуу зарцуулаад байна. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн батлагдсан төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах саналыг 01, 02, 05, 10, 11 дүгээр саруудад 01/177, 01/865, 01/1082, 01/1888, 01/2140 дүгээр албан бичгээр тус тус Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, холбогдох зардлыг шийдвэрлүүлсэн.	100
31.	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсөвт байгууллагуудын нэгтгэсэн тайлан балансыг нэгтгэн, санхүүгийн аудит хийлгэж, тодруулга, тайлбар гаргах	Урсгал зардал	Зөвлөмж, акт, албан шаардлага авсан эсэх (өсөлт, бууралт)	6/1/4	6/1/4 бууруулна	Төв болон боомт, орон нутаг дахь нэгжийн аудитлагдсан санхүүгийн тайланг нэгтгэж, төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайланг тайлбар, тодруулгын хамт боловсруулан энэ оны 01/491 дүгээр албан бичгээр Үндэсний аудитын газарт хүргүүлж, холбогдох баримт материал болон судалгааг хугацаанд нь гарган өгсөн. Үндэсний аудитын газрын хяналт шалгалтаар төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан “өөрчлөлтгүй” дүгнэгдэж, 7 зөвлөмж, 2 төлбөрийн акт авч, албан шаардлага аваагүй ажилласан болно. 2024 оны хагас жилийн нэгтгэсэн санхүүгийн тайланг гаргаж, 07 дугаар сарын 28-ны өдрийн 01/1504 дүгээр албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн ба төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагчийн 2024 оны нэг болон гуравдугаар улирлын санхүүгийн тайланг Сангийн яамны цахим системд байршуулж, баталгаажуулсан.	100
32.	Худалдан авах ажиллагааны 2024 оны ерөнхий төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж, үр дүнг тайлагнах	Урсгал зардал	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	97.5	100	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны А/412 дугаар тушаалаар баталсан 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 8 төрлийн 2,313.6 сая төгрөгийн өртөг бүхий төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу үнэлгээний хороо байгуулан тендерийг цахим системд нээлттэй	70

1	2	3	4	5	6	7	8
						зарлаж, 1 төсөл, арга хэмжээг харьцуулалтын, 4 арга хэмжээг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар, 1 арга хэмжээг ерөнхий гэрээний дагуу тус тус зохион байгуулж, 6 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан гүйцэтгэлийн дагуу санхүүжилтийг олгосон. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан нормын хувцас бэлтгэн нийлүүлэх болон мэдээллийн технологийн үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг тодорхой шалтгааны улмаас зарлаагүй болно. Төлөвлөгөөний хэрэгжилт 75 хувьтай байна.	
33.	Тэмдэгтийн хураамжийн орлого, торгуулийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхэд хяналт тавих	Урсгал зардал	Төвлөрүүлсэн орлогын дүн	14.1 тэрбум төгрөг	8 тэрбум төгрөг	Тайлант хугацаанд 21,474.8 сая төгрөгийн улсын тэмдэгтийн хураамж, 1,715.7 сая төгрөгийн торгуулийн орлого, нийт 23,190.5 сая төгрөгийг орон нутгийн төсөвт, виз, оршин суух үйлчилгээний хураамж болох 2,662.8 сая төгрөгийг улсын төсвийн дансанд тус тус төвлөрүүлж, орлого төвлөрүүлэлтэд сар бүр хяналт тавьж ажилласан.	100
34.	Дорноговь аймаг дахь газрын албаны байранд урсгал засвар хийж, сантехникийг шинэчлэх	Орон нутгийн төсөв	Засварын ажлын гүйцэтгэлийн хувь	50	100	Албаны байранд урсгал засвар хийх тендер шалгаруулалтад "Ивэн Өргөө" ХХК сонгогдож, орон нутгийн төсвийн 196,431,624 төгрөгийн хөрөнгө оруулалтаар сантехникийг шинэчлэн урсгал засварын ажлыг 100 хувь гүйцэтгэж, албан хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжрууллаа.	100
35.	Ханх автозамын боомт дахь албан хаагчдын амьдрах байрны иж бүрэн засвар, тохижилтын ажлыг гүйцэтгэх	Орон нутгийн төсөв	Засвар, тохижилтын ажлын хувь	-	100	Ханх авто замын боомт дахь албан хаагчдын амьдрах байранд урсгал засвар хийхээр орон нутгийн төсвөөс 19,373,437 төгрөгийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлж, энэ оны 05-07 дугаар саруудад дотоод хүний нөөцийн боломжоор иж бүрэн засвар болон тохижилтын ажлыг 100 хувь хийж гүйцэтгэсэн.	100
36.	Тэс автозамын боомтод албан хаагчид амьдрах байр бариулах	Орон нутгийн төсөв	Барилгын ажлын гүйцэтгэлийн хувь	-	100	Увс аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 16/04 дүгээр тогтоолоор Тэс авто замын боомтод албан хаагчдын амьдрах байр барих 60 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг батлуулж, барилгын зургийг "Барилгын инженерүүд" ХХК-аар гүйцэтгүүлэн УВАХААГ/20240201027 дугаартай тендерийг 09-11 дүгээр саруудад нийт 6 удаа	50

1	2	3	4	5	6	7	8
						нээлттэй зарласан боловч иргэн, аж ахуй нэгж байгууллагаас санал ирүүлээгүй. Тендерийг дахин зарлуулахаар төлөвлөж байна.	
37.	Дорнод аймгийн Хэрлэн суманд албан хаагчид амьдрах орон сууц шийдвэрлүүлэх	Орон нутгийн төсөв	Орон сууцтай болсон эсэх	-	1	Албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах, ая тухтай амьдрах нөхцөлийг хангахаар Дорнод аймгийн Хэрлэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 16/13 дугаар тогтоолоор орон сууц худалдан авах 180,000,000 төгрөгийн төсвийг батлуулж, худалдан авах гэрээг 2024 оны 08 дугаар сарын 01-ний өдөр байгууллаа.	100
Хэсгийн дундаж үнэлгээ: 94.1 хувь							
Стратегийн зорилго 2. Төрийн үйлчилгээнд мэдээллийн технологийн дэвшил, инновац нэвтрүүлэх замаар бүтээмж, үр ашгийг дээшлүүлнэ. (Шинэ сэргэлтийн бодлого-Төрийн бүтээмжийн сэргэлт 6.1), (Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл 5.3.2), (Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөний 2.5.2), (Гадаадын иргэн, харьяатын газрын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөний 3 дугаар зорилт)							
Зорилт 4. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт Инновацад суурилсан цахим шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлнэ.							
38.	Баримт бичгийн хуурмаглалыг таних, судлах чиг үүргийг хэрэгжүүлэх албан хаагч томилох, мэдээллийн систем хөгжүүлэх	Улсын төсөв	Хариуцах албан хаагч/мэдээллийн систем	-	1/1	Баримт бичгийн хуурмаглалыг таних тоног төхөөрөмж нийлүүлэх, сургалт зохион байгуулах чиглэлээр хамтарсан төсөл хэрэгжүүлэх хүсэлтийг төслийн санал, мэдээллийн системийн хэрэглэгчийн шаардлага, тоног төхөөрөмжийн судалгааны хамт Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагад 05 дугаар сарын 09-ний өдөр, Америкийн Нэгдсэн Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яаманд 05 дугаар сарын 14-ний өдөр тус тус цахимаар хүргүүлээд байна. Баримт бичгийн хуурмаглалыг таних, судлах чиг үүргийг Зөрчил шалган шийдвэрлэх газрын дарга, хяналтын улсын ахлах байцаагч болон байцаагч, боомт, орон нутаг дахь нэгжид нэгжийн дарга, хяналтын улсын ахлах байцаагч болон байцаагч нар хэрэгжүүлж ажиллахаар албан тушаалын тодорхойлолтод тусгасан болно.	70

1	2	3	4	5	6	7	8
39.	Виз мэдүүлгийн цахим системийн (e-form.mn) нэмэлт хөгжүүлэлт хийх	Урсгал зардал	Паспортын MRZ унших нэмэлт хөгжүүлэлт хийгдсэн эсэх	-	1	Виз мэдүүлгийн цахим системийн (e-form.mn) хөгжүүлэлтийг хийж, 09 дүгээр сарын 30-ны өдрөөс тестийн горимд шилжүүлэн 10 дугаар сарын 10-ны өдрөөс үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлэв.	100
40.	Объектын судалгааны программ хангамжийн нэмэлт хөгжүүлэлт хийх	Урсгал зардал	Түүвэрлэлт, хэрэглэгчийн эрхийн тохиргооны шинэчлэлт хийгдсэн эсэх	-	1	Объектын судалгааны программд түүвэрлэлт хийх, хэрэглэгчийн эрхийн тохиргоог шинэчлэх хөгжүүлэлтийг 04 дүгээр сарын 05-ны өдөр хийж, үйл ажиллагаанд нэвтрүүлсэн. Мөн тус системд нэмэлтээр засварлах шаардлагатай 4 бүлгийн 12 өөрчлөлтийг 04 дугаар сарын 30-ны өдөр хийж гүйцэтгэн бүрэн ажиллагаанд орууллаа.	100
41.	Цахим архивын программын нэмэлт хөгжүүлэлт хийх	Урсгал зардал	Интернэт орчинд ажиллах хөгжүүлэлт хийгдсэн эсэх	-	1	Цахим архивын программыг 02 дугаар сарын 05-ны өдөр дотоод сүлжээнээс интернэт орчинд шилжүүлж, шаардлагатай бүх өгөгдлийг байршуулан хандах тохиргоог хийж, үйл ажиллагаанд нэвтрүүлсэн. Программыг 09 дүгээр сарын 17-ны өдөр дахин шинэчилж, нэмэлт хөгжүүлэлт хийн серверийг Үндэсний дата төв УТҮГ дахь төрийн мэдээллийн Mcloud системээс байгууллагад нүүлгэн шилжүүлэв.	100
42.	Байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагааны тоон мэдээллийг хянах самбар (dashboard)-ын программ хангамжийг хөгжүүлж, үйл ажиллагаанд нэвтрүүлэх	Урсгал зардал	Программ хангамжийг хөгжүүлсэн эсэх	-	1	Эдийн засаг хөгжлийн яам, Азийн хөгжлийн банктай хамтран хэрэгжүүлж буй "МОН3936: Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төсөл"-ийн бүрэлдэхүүн хэсэг ЗҮ-03: "Гадаадын иргэний мэдээллийн нэгдсэн систем хөгжүүлэлт"-ийн хүрээнд 6 төрлийн үйлчилгээний дэлгэрэнгүй тоон мэдээллийг харуулах самбар (dashboard)-ыг "Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан" систем дээр хөгжүүлж, 03 дугаар сарын 07-ны өдрөөс үйл ажиллагаанд нэвтрүүлсэн. Гүйцэтгэгч байгууллагатай хийсэн гэрээний хугацаа 12 дугаар сарын 10-ны өдөр дуусах тул иргэдэд үзүүлж буй бүх үйлчилгээний дэлгэрэнгүй тоон мэдээллийг харуулах хөгжүүлэлтийг тус хугацаанд хийж дуусгахаар ажиллаж байна.	90

1	2	3	4	5	6	7	8
43.	Иргэдэд зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээг өргөжүүлэн зохион байгуулах	Урсгал зардал	Зохион байгуулалтын ажлын хувь	-	100	Гадаадын иргэн, харьяатын газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн батлах тухай Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн А/129 дүгээр тушаалаар Зөвлөгөө, мэдээллийн хэлтсийг дарга 1, ахлах мэргэжилтэн 1, мэргэжилтэн 5, нийт 7 орон тоотойгоор байгуулж, иргэдэд виз, оршин суух зөвшөөрөл болон бусад холбогдох зөвлөгөө, мэдээлэл хүргэх үйлчилгээг өргөжүүллээ.	100
44.	Оршин суух үнэмлэх хэвлэх хүчин чадлыг нэмэгдүүлж, үйлчилгээг өргөжүүлэх	Урсгал зардал	Зохион байгуулалтын ажлын хувь	-	100	Төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, иргэдийн цаг, зардлыг хэмнэх, үйлчилгээний төвлөрлийг сааруулах зорилгоор оршин суух үнэмлэх хэвлэх, олгох үйлчилгээг 02 дугаар сарын 07-ны өдрөөс Чингэлтэй дүүргийн Улсын бүртгэлийн нэг цэгийн үйлчилгээний төвд шилжүүлэв. Мөн КГВ хүргэлтийн үйлчилгээг “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” системд нэвтрүүлэн оршин суух үнэмлэх хүргэлтийг зохион байгуулж байна. Оршин суух үнэмлэх хэвлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, хэвлэх үйл ажиллагааг хялбаршуулах хүрээнд Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Засаг даргын Тамгын газраас зарласан ДГАЗҮСЗДТГ/20240102013 дугаар тендер шалгаруулалтаар оршин суух үнэмлэх хэвлэх принтер 1 ширхэг, өөрөө хэвлэгч киоск машин 1 ширхгийг тус тус худалдан авсан. Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангаас үнэмлэх хэвлэх сервисийн хөгжүүлэлтийг хийн 09 дүгээр сарын 30-ны өдөр бэлэн болгож, киоск машины программын хөгжүүлэлтийг 11 дүгээр сарын 08-ны өдрийн 01/09-20 дугаар гэрээгээр Ньюкомпас ХХК-аар гүйцэтгүүлэн төстийн горимд шилжүүлээд байна.	100
Хэсгийн дундаж үнэлгээ: 94.3 хувь							

1	2	3	4	5	6	7	8
Нийт үнэлгээ: 95.9 хувь							

--oo0oo--